



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/1975

Мандалговь

Гамшгаас хамгаалах орон тооны
бус албад, тусгай зориулалттай
мэргэжлийн ангиудыг шинэчлэн
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны "Мэргэжлийн ангийн дүрэм батлах тухай" 75 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны "Журам батлах тухай" А/865 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий "Орон нутгийн гамшгаас хамгаалах алба"-ыг нэгдүгээр хавсралтаар, "гамшгаас хамгаалах тусгай зориулалтын мэргэжлийн анги"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хууль, эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд гамшгаас хамгаалах үүрэг бүхий бүрэлдэхүүнийг тухай бүрд нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Анхбаяр), Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Ц.Төрбилэг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг байгууллагынхаа онцлогт тохируулан журамд заагдсан бүтэц, орон тоогоор томилгоожуулан, эрх зүйн баримт бичгийн төлөвлөлтөд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг агентлаг, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/13 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100728